



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 03 дугаар сарын 07  
№10 (1258)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

162. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 763

#### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

163. Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай Дугаар 01 764

164. Шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай Дугаар 03 764

#### МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

165. Монгол Улс болон Олон улсын хөгжлийн  
ассоциацийн хоорондын Зээлийн хэлэлцээр  
(Ухаалаг засаг II төсөл) 765



᠒᠑᠘᠐	<p>ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ (ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ ᠰᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ) ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ /ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ ᠰᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ</p> <p><b>Мэдээлэл Folo_ 02 Fola Folo_ 02 Kf* I</b></p>	᠒᠑᠙᠕
᠒᠑᠗᠐	<p>ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ /ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ ᠰᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ</p> <p>ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ /ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ ᠰᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ</p> <p><b>Мэдээлэл Folo_ 02 Verodkhiilec I iia Jvli(</b></p>	᠒᠑᠙᠗
᠒᠑᠔᠐	<p>ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ /ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ ᠰᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ</p> <p><b>Мэдээлэл Folo_ 02 Høll</b></p>	᠒᠑᠙᠙

ᠮᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ



### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

#### ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улс болон Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан “Ухаалаг засаг II төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio\_02 NEW

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠰᠤᠰᠤᠭᠤᠨ ᠭ᠋ᠠᠵᠤᠷᠢᠨ ᠥᠷᠭᠦᠨ ᠮᠡᠳᠦᠭᠦᠯᠰᠢᠨᠭᠡᠷ ᠰᠡ᠎ᠡᠷᠬᠣᠨ ᠪᠠᠲᠠᠯᠰᠤᠭᠠᠢ

ᠲᠡᠭᠦᠷ ᠵᠢᠢᠨ ᠬᠡᠯᠡᠯᠠᠵᠡᠷᠢᠭᠡᠢ ᠰᠣᠶᠢᠷᠬᠣᠨ ᠪᠠᠲᠠᠯᠠᠭ ᠲᠤᠬᠤᠠᠢ

ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭ ᠰᠤᠰᠤᠭᠤᠨ ᠭ᠋ᠠᠵᠤᠷᠢᠨ ᠥᠷᠭᠦᠨ ᠮᠡᠳᠦᠭᠦᠯᠰᠢᠨᠭᠡᠷ ᠰᠡ᠎ᠡᠷᠬᠣᠨ ᠪᠠᠲᠠᠯᠠᠭ ᠲᠤᠬᠤᠠᠢ ᠵᠢᠢᠨ ᠬᠡᠯᠡᠯᠠᠵᠡᠷᠢᠭᠡᠢ ᠰᠣᠶᠢᠷᠬᠣᠨ ᠪᠠᠲᠠᠯᠠᠭ ᠲᠤᠬᠤᠠᠢ ᠵᠢᠢᠨ ᠬᠡᠯᠡᠯᠠᠵᠡᠷᠢᠭᠡᠢ ᠰᠣᠶᠢᠷᠬᠣᠨ ᠪᠠᠲᠠᠯᠠᠭ ᠲᠤᠬᠤᠠᠢ

ᠭᠡᠷᠢᠨᠠᠭᠤᠯᠠᠭ ᠰᠤᠰᠤᠭᠤᠨ ᠭ᠋ᠠᠵᠤᠷᠢᠨ ᠥᠷᠭᠦᠨ ᠮᠡᠳᠦᠭᠦᠯᠰᠢᠨᠭᠡᠷ ᠰᠡ᠎ᠡᠷᠬᠣᠨ ᠪᠠᠲᠠᠯᠠᠭ ᠲᠤᠬᠤᠠᠢ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 01 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Армени Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дуламсүрэнгийн Давааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Армени Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Өлзийсайханы Энхтүвшинг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 01 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 353 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Бямбын Мөнхтуяаг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

**ЗЭЭЛИЙН ДУГААР 7090-МН**

**МОНГОЛ УЛС**

**болон**

**ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИЙН**

**хоорондын**

**Зээлийн хэлэлцээр**

**(Ухаалаг засаг II төсөл)**

## ЗЭЭЛИЙН ДУГААР 7090-МН

### ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Зээлийн Хэлэлцээрийг Монгол Улс (цаашид "Зээлдэгч" гэх) болон Олон улсын хөгжлийн ассоциаци (цаашид "Ассоциаци" гэх)-ийн хооронд доор заасан гарын үсэг зурсан өдөр байгуулав. Зээлдэгч болон Ассоциаци дараах зүйлсийг зөвшөөрч тохиролцов:

#### ЗҮЙЛ I - ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, НЭР ТОМЬЁО

- 1.01. Ерөнхий нөхцөл (энэ Хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсон) нь энэхүү хэлэлцээрт хамаарах бөгөөд энэ Хэлэлцээрийн нэг хэсэг мөн.
- 1.02. Хэлэлцээрийн агуулга нь өөрөөр заагаагүй бол энэхүү Хэлэлцээрт буй том үсгээр бичсэн нэр томьёог Ерөнхий нөхцөл, эсвэл энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад тайлбарласан утгаар ойлгоно.

#### ЗҮЙЛ II - САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь Ерөнхий нөхцөлийн хүрээнд "Хөнгөлөлттэй зээл" гэж үзэх хорин есөн сая таван зуун мянган зээлжих тусгай эрх [29,500,000 ЗТЭ]-тэй тэнцэх дүнтэй (өөрөөр "Зээл" ба "Санхүүжилт") зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-д заасан төслийг ("Төсөл") санхүүжүүлэхэд зориулан Зээлдэгчид олгохыг зөвшөөрөв.
- 2.02. Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг III-т заасны дагуу Зээлийн хөрөнгийг татан авч болно.
- 2.03. Зээлийн хөрөнгийн хураамжийн дээд хэмжээ нь Татан аваагүй зээлийн үлдэгдлийн дүнгийн жилийн нэг хувийн хагастай (1%-ийн 1/2) тэнцүү байна.
- 2.04. Үйлчилгээний хураамж нь Татан авсан зээлийн үлдэгдэл дүнгийн жилийн нэг хувийн дөрөвний гуравтай (1%-ийн 3/4) тэнцүү байна.
- 2.05. Хүүгийн хураамж нь Татан авсан зээлийн үлдэгдлийн дүнгийн жилийн нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх огноо нь жил бүрийн 03 дугаар сарын 15-н болон 09 дүгээр сарын 15-ны өдөр байна.



- 2.07. Зээлийн үндсэн төлбөрийг энэ Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө.
- 2.08. Төлбөрийн валют нь доллар байна.

### **ЗҮЙЛ III - ТӨСӨЛ**

- 3.01. Зээлдэгч нь Төслийг зорилгынх нь дагуу хэрэгжүүлэхээ үүгээр баталгаажуулж мэдэгдэв. Үүний тулд Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрийн Ерөнхий нөхцөлийн Зүйл V, Хуваарь 2-т заасны дагуу Төслийг хэрэгжүүлнэ.

### **ЗҮЙЛ IV - ХЭЛЭЛЦЭЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ЦУЦЛАХ**

- 4.01. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох нэмэлт нөхцөл нь Зээлдэгч талаас Ассоциацийн хүлээн зөвшөөрсөн хэлбэр, агуулгатай Төслийн үйл ажиллагааны гарын авлагыг баталснаар хангагдана;
- 4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зуун наян (180) хоногийн дараах өдөр байна.
- 4.03. Ерөнхий нөхцөлийн 10.05(б) хэсгийн хувьд, Зээлдэгчийн энэхүү хэлэлцээрээр хүлээсэн үүрэг (төлбөрийн үүрэгт зааснаас бусад) дуусгавар болох огноо нь гарын үсэг зурсан өдрөөс хойш хорин (20) жил байна.

### **ЗҮЙЛ V – ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧ, ХАЯГ**

- 5.01. Зээлдэгчийн Төлөөлөгч нь сангийн асуудал эрхэлсэн Сайд байна.
- 5.02. Ерөнхий нөхцөлийн 11.01-д заасныг хэрэгжүүлэхэд Зээлдэгчийн дараах хаягийг ашиглана:

(а) Зээлдэгчийн хаяг нь:

Сангийн яам  
Засгийн газрын II байр  
С.Данзангийн гудамж 5/1 Д  
Улаанбаатар 15160  
Монгол Улс;

(б) Зээлдэгчийн цахим хаяг нь:

Факс: 976-11-320247





5.03. Ерөнхий нөхцөлийн 11.01-д заасныг хэрэгжүүлэхэд Ассоциацийн дараах хаягийг ашиглана:

(а) Ассоциацийн хаяг:

Олон улсын хөгжлийн ассоциаци  
1818 Н гудамж, N.W.  
Вашингтон, ДС 20433  
Америкийн Нэгдсэн Улс;

(б) Ассоциацийн цахим хаяг нь:

Телекс:	Факс:
248423(MCI)	1-202-477-6391



Гарын үсэг зурсан өдөр, ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСАН:

**МОНГОЛ УЛС**

**Эрх бүхий төлөөлөгч**

Нэр: \_\_\_\_\_  
Албан тушаал: \_\_\_\_\_  
Огноо: \_\_\_\_\_

**ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ**

**Эрх бүхий төлөөлөгч**

Нэр: \_\_\_\_\_  
Албан тушаал: \_\_\_\_\_  
Огноо: \_\_\_\_\_

## ХУВААРЬ 1

### Төслийн тодорхойлолт

Төслийн зорилго нь иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн цахим үйлчилгээний хэрэглээ, үр ашгийг сайжруулах, дижитал ур чадвар болон дижитал суурьтай ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Төсөл дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй:

#### Бүрэлдэхүүн хэсэг 1: Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх

- 1.1. Дижитал шилжилтийн бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх: Дижитал шилжилттэй холбоотой хууль эрх зүй, зохицуулалт, бодлого, институтийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүн шинжилгээ хийж, техникийн туслалцаа үзүүлэх.
- 1.2. Төслийн дижитал засаглалын чиглэлээрх хөрөнгө оруулалтуудад зориулсан өөрчлөлтийн болон оролцогч талуудын менежмент: (а) Өөрчлөлтийн менежментийн үнэлгээ хийж, төрийн дижитал шилжилтийн хөрөнгө оруулалтыг нэвтрүүлэх, ашиглахад тулгарч буй бэрхшээлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах; (б) холбогдох төрийн албан хаагчид болон оролцогч талуудад өөрчлөлтийг манлайлах, мэдээлэх талаар чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- 1.3. Иргэдийн цахим оролцоог хөхиүлэн дэмжих: Олон нийт, нийгмийн бүлгүүдтэй харилцах онлайн платформ, хэрэгслийг хэрэгжүүлэх, ашиглах.

#### Бүрэлдэхүүн хэсэг 2: Дижитал засгийн шилжилт

- 2.1. Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, үр ашигтай байдлыг дээшлүүлэх, стратегийн үйлчилгээ үзүүлэх:
  - (a) Сонгогдсон төрийн үйлчилгээг цахимжуулж E-Mongolia порталд байршуулах, төрийн цахим үйлчилгээний стандартыг боловсруулах;
  - (b) (i) одоо байгаа цахим худалдан авалтын системийн үйл ажиллагааг өргөжүүлэх, (ii) бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл онлайнгаар олгох нэг цонхны систем хөгжүүлэх,

(iii) ашиг сонирхлын зөрчил, орлого, хөрөнгийн мэдүүлгийн системийн хоёр дахь үе шатыг хэрэгжүүлэх. (iv) кодчиллын цахим мэдээллийн сан, цахим шийдвэр гаргах, архивлах, гүйцэтгэлийн удирдлага болон дижитал кабинетын тогтолцоог хөгжүүлэх, (v) үндэсний аялал жуулчлалын нэгдсэн платформыг шинэчлэх, тогтвортой ажиллагааг хангах, (vi) мод тарилт, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн бүртгэлийн онлайн систем хөгжүүлэх, (vii) цахимжуулсан хууль тогтоомж, УИХ-ын хуралдааны бичлэгээр иргэдийг хангах онлайн систем хөгжүүлэх зэргээр стратегийн ач холбогдол бүхий нэгдсэн цахим үйлчилгээг хэрэгжүүлэх.

2.2. Үндэсний дата төв болон Нөөц дата төвийг шинэчлэх: Одоо байгаа Үндэсний дата төв, Нөөц дата төвийн үйл ажиллагааг сайжруулах үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, үүнд: (а) төвүүдийн техник хангамжийн хүчин чадлыг сайжруулж, үндэсний үүлэн тооцооллын платформ болгон хувиргах; (б) холбогдох төрийн байгууллагуудын дундын хэрэглээнд зориулсан нийтлэг үйлчилгээ идэвхжүүлэгчийг нэмэх; (в) арилжааны үүлэн тооцооллын үйлчилгээ ашиглах боломжийг үнэлэх, төвлөрсөн бус дэд бүтэц бүхий захын тооцооллын загварыг нэвтрүүлэх; (г) мэдээллийн төвүүдийн хөргөлтийн болон эрчим хүчний системийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх.

2.3. Үндэсний Кибер аюулгүй байдлын харуу арга хэмжээний багийн чадавхыг нэмэгдүүлэх. Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бэхжүүлнэ: (а) Үндэсний хэмжээний кибер аюулгүй байдлын яаралтай тусламжийн багийг байгуулж, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх; (б) Улсын бүртгэлийн ерөнхий газрын нөөц төвийг техник хангамж, мэдээллийн сан, аюулгүй байдлын лицензээр хангах замаар системийн аюулгүй байдлыг бэхжүүлэх.

### **Бүрэлдэхүүн хэсэг 3: Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих**

3.1. Төрийн албан хаагчид, иргэдийн дижитал үр чадварыг нэмэгдүүлэх: (а) төрийн болон төрийн захиргааны албан хаагчдад дижитал технологийн практик үр чадвар олгох сургалт явуулах; (б) улсын хэвшлийн дижитал үр чадварын сургалтын стратеги боловсруулж, засгийн газрын онлайн сургалтын порталыг сайжруулах; (в) холбогдох төрийн байгууллагуудын дижитал чадавхыг сайжруулахад чиглэсэн чадавхыг бэхжүүлэх дэмжлэг

үзүүлэх; (г) зорилтот бүлгийн иргэдэд дижитал ур чадварын үндсэн ба шаардлагатай мэдлэгийг олгох дижитал бичиг үсгийн хөтөлбөр хэрэгжүүлэх; (д) сургалтын хөтөлбөр, агуулгыг баримтжуулах, суралцагчдад үнэлгээ өгөх, сургалтын статистик мэдээлэл гаргах, цахим гэрчилгээ олгоход зориулсан иргэдийн цахим бичиг үсгийн платформыг хөгжүүлэх.

3.2. Дижитал технологид суурилсан ажлын байр (3,000) бий болгох: (а) дижитал ур чадварын суурь мэдлэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрт тусгах ажлыг дэмжих; (б) мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) чиглэлийн зорилтот оюутнуудад МХХТ-ийн мэргэжилтнүүдэд шаардлагатай дижитал ур чадвар, танин мэдэхүйн болон нийгэм-сэтгэл хөдлөлийн үндсэн ур чадвар олгох сургалт явуулах; (в) дотоодын мэдээллийн технологийн сонгогдсон компаниудад сургалтын дэмжлэг үзүүлэх зэргээр залуучуудад зориулсан ажлын байр бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх.

3.3. Жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДБЭ) үйл ажиллагаандаа дижитал технологийн шийдлийг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх: (а) ЖДБЭ-ийн бизнесийн тасралтгүй ажиллагааг хангахад зориулсан дижитал шилжилтийн замын зураглалыг боловсруулах; (б) үйл ажиллагааг цахимжуулах сонирхолтой ЖДБЭ-д техникийн туслалцаа үзүүлэх; (в) залуучуудыг дижитал технологид суурилсан ажилд авах, ажил олгох ЖДБЭ-д зориулсан ажлын байранд зуучлах үйл ажиллагаа хэрэгжүүлэх; (г) ЖДБЭ-д олноор, нийтлэг хэрэглэхэд зориулсан хэрэглээний программуудыг зах зээлд бий болгоход дэмжлэг үзүүлэх.

#### **Бүрэлдэхүүн хэсэг 4. Төслийн менежментийн дэмжлэг**

Төслийн удирдлага, зохицуулалт, түүний дотор санхүүгийн удирдлага, зарцуулалт, худалдан авалт, байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн удирдлага, гомдол барагдуулах механизм, хяналт шинжилгээ, тайлагналт, үнэлгээ зэрэгт техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх.

#### **Бүрэлдэхүүн хэсэг 5. Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ**

Хүлээн зөвшөөрөхүйц хямрал, онцгой байдлын үед шаардлагатай хариу арга хэмжээг шуурхай авах.

## ХУВААРЬ 2

### ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

#### Хэсэг I. Хэрэгжүүлэлтийн зохицуулалтууд

##### **A. Институтийн зохион байгуулалт**

1. Зээлдэгч нь Төслийг хэрэгжүүлэх бүх хугацаанд үндэсний болон орон нутгийн түвшинд Төслийн хэрэгжилтийн бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, орон тоо, нөөцийг Ассоциацийн хүлээн зөвшөөрсөн Төслийн үйл ажиллагааны гарын авлагад тусгасан дагуу хадгалж ажиллана.
2. Дээр дурдсан зүйлээр хязгаарлахгүйгээр Зээлдэгч нь:
  - (a) Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохицуулалтыг хангах зэрэг үүрэгтэй Төслийн Удирдах хороог үргэлжлүүлэн ажиллуулна;
  - (b) Төслийн өдөр тутмын хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах, түүний дотор Төслийн (i) жилийн ажлын төлөвлөгөө, төсөв боловсруулах, (ii) худалдан авалт, санхүүгийн удирдлага, байгаль орчны нийгмийн нөлөөлөл ба эрсдэлийн удирдлагыг хангах, (iii) хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх Төсөл хэрэгжүүлэх нэгжийг үргэлжлүүлэн ажиллуулна.

##### **B. Төслийн үйл ажиллагааны гарын авлага**

1. Зээлдэгч нь Төслийн үйл ажиллагааны гарын авлагыг бэлтгэн баталж, цаашид Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан зохицуулалт, журмын дагуу (Төслийн үйл ажиллагааны гарын авлага болон энэхүү Хэлэлцээрийн заалтуудын зохицуулалт, журмын хооронд зөрчил гарсан тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөнө) төслийг хэрэгжүүлэх бөгөөд Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд Төслийн үйл ажиллагааны гарын авлагын аливаа заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, татгалзах үйлдэл гаргаж үл болно.

**С. Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв**

1. Зээлдэгч нь Төслийг хэрэгжүүлэх явцад жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг (ЖАТТ) нэгтгэн бэлтгэж санхүүгийн жил бүрийн 12-р сарын 31-ний өдрөөс хойшгүй хугацаанд (эсвэл Ассоциациас зөвшөөрсөн өөр өдөр) хүргүүлж Ассоциациас зөвшөөрөл авна. Жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөө, төсөвт дараагийн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Төслийн бүх үйл ажиллагаа, зарлага, түүний дотор бүх зардлын санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхойлолт, энэ Хуваарийн D хэсэгт заасны дагуу авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөг удирдах арга хэмжээг багтаана.
2. Зээлдэгч нь тухайн санхүүгийн жилд Ассоциациас хүлээн зөвшөөрөгдсөн ЖАТТ-ийн дагуу Төслийн хэрэгжилтийг хангана. Хэрэв ЖАТТ болон энэхүү Хэлэлцээрийн заалтуудын хооронд ямар нэгэн зөрчил гарсан тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтыг баримтална.
3. Зээлдэгч нь Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ЖАТТ-д ямар нэг өөрчлөлт оруулах, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх ёсгүй.

**D. Байгаль орчин, нийгмийн стандарт**

1. Зээлдэгч нь Байгаль орчин, нийгмийн стандартад нийцүүлэн, Ассоциацид хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар Төслийг хэрэгжүүлнэ.
2. Зээлдэгч нь дээрх 1 дэх заалтаар хязгаарлахгүйгээр Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөний ("БОНХТ") дагуу Ассоциацийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар төслийг хэрэгжүүлнэ. Энэ зорилгоор Зээлдэгч нь дараах үүрэг хүлээнэ:
  - (a) БОНХТ-нд заасан үйл ажиллагаа, арга хэмжээг БОНХТ-д тодорхойлсны дагуу зохих ёсоор, үр ашигтай хэрэгжүүлэх;
  - (б) БОНХТ хэрэгжүүлэх зардлуудыг даах хангалттай хэмжээний санхүүжилттэй байх;
  - (в) БОНХТ-нд тусгасан бодлого, дүрэм, журмыг сахин мөрдөж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хангалттай тооны мэргэшсэн, туршлагатай боловсон хүчинтэй байх;

- (г) БОНХТ-нд заасны дагуу Ассоциацитай өөрөөр бичгээр тохиролцоноос бусад тохиолдолд БОНХТ, эсвэл түүний аливаа заалтыг өөрчлөх, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, татгалзахгүй байх. БОНХТ-г шинэчилсэн тохиолдолд шинэчилсэн хувийг нэн даруй ил болгох.
3. БОНХТ болон энэхүү Хэлэлцээрийн заалтуудын хооронд ямар нэгэн зөрчил гарсан тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтыг баримтална.
4. Зээлдэгч нь дараах шаардлагыг хангасан байна:
- (а) БОНХТ-нд заасан давтамжтайгаар тогтмол тайланг боловсруулж мэдээлэл цуглуулах, нэгтгэх, Ассоциацид хүргүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна. Хэрэв Ассоциациас БОНХТ-ний биелэлтийн байдал болон түүний байгаль орчин, нийгмийн арга хамгааллын хэрэгслүүдийн талаар мэдээлэл хүссэн бол энэ тухай тусдаа тайланг даруй гаргаж өгнө. Эдгээр бүх тайланг Ассоциацид хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгатайгаар боловсруулах бөгөөд түүний дотор (i) БОНХТ-ний хэрэгжилтийн байдал; (ii) БОНХТ-г хэрэгжүүлэхэд саад учруулсан, эсвэл саад учруулахаар заналхийлсэн нөхцөл байдал (хэрэв үүссэн бол); (iii) ийм нөхцөл байдлыг арилгахаар авсан, эсвэл авах шаардлагатай засаж залруулах ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэргийг тусгана;
- (б) БОНХТ болон үүнтэй холбоотой байгаль орчин, нийгмийн арга хэрэгсэл, стандартад заасны дагуу байгаль орчин, нөлөөлөлд өртсөн ард иргэд, олон нийт, ажилчдад ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа, үзүүлэх магадлалтай, Төсөлтэй холбоотой, эсвэл Төсөлд нөлөөлөхүйц аливаа осол, аваарын талаар Ассоциацид нэн даруй мэдэгдэнэ.
5. Зээлдэгч нь Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хялбар нэвтрэх боломжтой Гомдол барагдуулах механизмыг бий болгож, нийтэд мэдээлэх, үйлчилгээ хийх, ажиллуулах бөгөөд ийм санал гомдлыг Ассоциаци хүлээн зөвшөөрөхүйц байдлаар шийдвэрлэх, эсвэл шийдвэрлэхэд туслах бүхий л шаардлагатай бөгөөд тохиромжтой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



6. Зээлдэгч нь Төслийн хүрээнд хийгдэх бүх сонгон шалгаруулалтын бичиг баримт, барилгын ажлын хэлэлцээрт гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, хяналтын байгууллагын дараах үүргийг тусгана: (а) БОНХТ-ний холбогдох заалтууд, түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн хэрэгслүүдийг дагаж мөрдөх; (б) байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлийг арилгах талаар нарийвчлан тусгасан ёс зүйн дүрмийг боловсруулж бүх ажилчдад танилцуулан гарын үсэг зуруулж мөрдүүлэх, түүнийг уг хэлэлцээрийн дагуу эхлүүлсэн, хэрэгжүүлсэн бүх барилгын ажилд мөрдлөг болгоно.

### **Е. Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ**

1. Зээлдэгч нь “Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ” гэсэн Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 5-д заасан арга хэмжээг зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд дараах нөхцөлийг бүрдүүлнэ:
- (а) Онцгой байдлын хариу арга хэмжээ хэрэгжүүлэх дэлгэрэнгүй зохицуулалтыг тусгасан гарын авлагыг (“CERC гарын авлага”) Ассоциаци хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгатайгаар бэлтгэж, батална. Үүнд: (i) Онцгой байдлын хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, зохицуулах байгууллагын бүтэц, институтийн зохион байгуулалт; (ii) Онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэгт оруулж болох тодорхой үйл ажиллагаа, улмаар тэдгээрт шаардагдах Зөвшөөрөх зардал (“Онцгой байдлын зардал”), ийнхүү оруулахад баримтлах журам; (iii) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэгт зориулсан санхүүгийн менежментийн зохицуулалт; (iv) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэгт зориулсан худалдан авалтын арга, журам; (v) Онцгой байдлын зардлын санхүүжилтийг татан авахад шаардагдах баримт бичиг; (vi) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэгт зориулсан байгаль орчин, нийгмийн үнэлгээ, удирдлагын зохицуулалт; (vii) Онцгой байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар зэргийг оруулсан байна;
- (б) Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөг Ассоциаци хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгаар боловсруулж батална;



- (в) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсгийг “CERC гарын авлага” болон Онцгой байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ, ингэхдээ “CERC гарын авлага”, Үйл ажиллагааны төлөвлөгөө болон энэхүү Хэлэлцээрийн заалтуудын хооронд зөрчил гарсан бол энэхүү Хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө;
- (г) Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр “CERC гарын авлага” болон Онцгой байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, цуцлах хүчингүй болгох, татгалзах ёсгүй.
2. Зээлдэгч нь Онцгой байдлын хариу арга хэмжээний хэсгийг хэрэгжүүлэх явцад “CERC гарын авлага”-д заасан бүтэц, зохион байгуулалтыг хадгалж Ассоциаци хангалттай гэж үзэхүйц хэмжээний боловсон хүчин, нөөцөөр хангана.
3. Зээлдэгч нь дараах шаардлагыг хангана:
- (а) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэгт шаардлагатай байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийг “CERC гарын авлага” болон БОНХТ-д заасны дагуу болон Ассоциаци хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгаар боловсруулж батлан нийтэд мэдээлнэ;
- (б) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсгийг байгаль орчин, нийгмийн хэрэгслүүдийн дагуу болон Ассоциаци хүлээн зөвшөөрөхүйц байдлаар хэрэгжүүлнэ.
4. Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэгт заасан үйл ажиллагааг зөвхөн Хүлээн зөвшөөрөхүйц хямрал, онцгой байдал үүссэний дараа хэрэгжүүлнэ.

## **Хэсэг II. Төслийн хяналт шинжилгээ, тайлагналт, үнэлгээ**

### **A. Төслийн тайлан**

Зээлдэгч нь Төслийн улирлын тайлан бүрийг тухайн хуанлийн улирал дууссанаас хойш нэг сарын хугацаанд багтаан Ассоциацид ирүүлнэ.



**Б. Дунд хугацааны үнэлгээ**

Зээлдэгч нь: (а) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш гучин зургаан (36) сарын дараах өдөр, эсвэл уг өдрийн орчимд Дунд хугацааны тайлан боловсруулж Ассоциацид хүргүүлнэ. Ингэхдээ Ассоциацийн зүгээс хүссэн хэмжээгээр дэлгэрэнгүй тайлагнаж, тайлан бичсэн өдрийн өмнөх хугацаанд төслийг хэрэгжүүлэх явцад гарсан ахиц дэвшлийг баримтжуулан, энэ Хэсгийн А-д заасны дагуу гүйцэтгэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг харгалзан, цаашид тайлангийн дараагийн үед төслийг үр ашигтай үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зорилгуудаа биелүүлэхийн тулд авбал зохих арга хэмжээг тодорхойлж тайлагнана; (б) Ассоциаци уг тайланг хүлээн авснаас хойш дөчин тав (45) орчим хоногийн дараах өдөр, эсвэл тэр өдөр орчимд хянаж дуусгах бөгөөд үүний дараа Дунд хугацааны тайланд өгсөн дүгнэлт, санал зөвлөмж, энэ талаарх Дэлхийн Банкны байр суурийг харгалзан Төслийг цаашид үргэлжлүүлэн үр ашигтай хэрэгжүүлэх, зорилгодоо хүрэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллана.

**Хэсэг III. Санхүүжилтийн хөрөнгийн татан авалт**

**А. Ерөнхий зүйл**

Хэлэлцээрийн Ерөнхий нөхцөлийн Зүйл II-ын заалтуудаар хязгаарлахгүйгээр, Зарцуулалт болон санхүүгийн мэдээллийн захидлыг үндэслэн Зээлдэгч нь Зөвшөөрөгдөх зардлыг хуваарилсан хэмжээгээр санхүүжүүлэх зорилгоор, хэрэв тохиромжтой бол дараах хүснэгтэд заасан “Ангилал” тус бүрд ногдох хувьд хүртэл хэмжээгээр Санхүүжилтийн хөрөнгийг татан авч болно.

Ангилал	Хуваарилагдсан санхүүжилтийн хэмжээ (ЗТЭ-ээр илэрхийлсэн)	Санхүүжүүлэх зардлын хувь (татвар орсон)
(1) Бараа бүтээгдэхүүн, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, Үйл ажиллагааны зардал, Төслийн сургалт	29,500,000	100%
(2) Онцгой байдлын зардал	0	
<b>НИЙТ ДҮН</b>	29,500,000	

## **Б. Татан авалтын нөхцөл, татан авалтын хугацаа**

1. Дээрх А хэсгийн заалтыг үл харгалзан, дараах тохиолдолд татан авалт хийгдэхгүй:

- (a) Гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн төлбөрт татан авалт хийхгүй. Гэхдээ энэ өдрөөс өмнө буюу 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, эсвэл түүнээс хойших хугацаанд хийсэн төлбөрийн “Ангилал (1) ”-ийн хүрээнд Зөвшөөрөгдөх зардалд зориулж нийтдээ 5,900,000 ЗТЭ-ээс хэтрэхгүй хэмжээний нийт дүнтэй татан авалт хийж болно;
- (б) Ангилал (2)-т хамаарах Онцгой байдлын зардалд, тухайн зардалтай холбоотой дараах бүх нөхцөл хангагдаагүй тохиолдолд болон хангагдах хүртэл татан авалт хийхгүй:
  - (i) (А) Зээлдэгч нь Онцгой гэж үзэхүйц байдал, хямрал үүссэнийг тогтоож, Ангилал (2)-т заасан санхүүжилтийн дүнг татан авах хүсэлтээ Ассоциацид хүргүүлсэн; (Б) Ассоциаци үүнтэй санал нийлж, хүсэлтийг хүлээн авч, энэ тухайгаа Зээлдэгчид мэдэгдсэн;
  - (ii) Зээлдэгч нь Ассоциаци хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгатай “CERC гарын авлага” болон Онцгой байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж баталсан.

2. Хаалтын огноо нь 2027 оны 07 дугаар сарын 30-ны өдөр байна.

## **Хэсэг IV. Бусад асуудлууд**

- A. Төслийн 2.1 дэх хэсгийг хэрэгжүүлэхийн тулд Зээлдэгч нь хэлэлцээр Хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван хоёр (12) сарын дотор E-Mongolia портал дээрх төрийн үйлчилгээнд зориулсан дижитал үйлчилгээний стандартыг боловсруулж Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх хэлбэр, агуулга, байдлаар нэвтрүүлэх ёстой.
- B. Зээлдэгч нь хэлэлцээр Хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван найман (18) сарын дотор (эсвэл Ассоциацитай бичгээр тохиролцсон хожмын өдөр) дараах зүйлсийг хэрэгжүүлнэ. Үүнд:



(а) Зээлдэгч нь Төслийн хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ЦХХХЯ-нд (эсвэл Ассоциацитай тохиролцсон бусад төрийн байгууллагад) шилжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Төслийг тасралтгүй үр ашигтай хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээг тусгасан шилжилтийн төлөвлөгөө боловсруулж Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд бэлтгэж, ирүүлнэ; (б) үүний дараа Ассоциациас хүлээн зөвшөөрсөн шилжилтийн төлөвлөгөөг Төслийн үйл ажиллагааны гарын авлагад тусгаж, уг төлөвлөгөөг Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх байдлаар хэрэгжүүлнэ.

### ХУВААРЬ 3

#### ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

Төлбөр хийх огноо	Зээлийн үндсэн хэсгийг эргэн төлөх дүн (хувиар илэрхийлэв)*
Жил бүрийн 3 дугаар сарын 15, 9 дүгээр сарын 15-ны өдөр:	
2027 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2047 оны 3 дугаар сарын 15-ны өдрийг оруулан	1.65%
2047 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2052 оны 3 дугаар сарын 15-ны өдрийг оруулан	3.40%

\* хувь хэмжээ нь зээлийн үндсэн төлбөрийн хэдэн хувийг эргүүлж төлөхийг илэрхийлэх бөгөөд Ассоциациас Ерөнхий нөхцөлийн 3.05 (б) хэсэгт заасны дагуу өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрэглэнэ.

### ХАВСРАЛТ

#### НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1. “Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв” буюу “ЖАТТ” гэсэн товчлол нь тус бүр Төслийн хэлэлцээрийн Хуваарийн I.C хэсэгт дурдсан төлөвлөгөө, төсвийг илэрхийлнэ. Уг төлөвлөгөөг Банкнаас урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлтэйгөөр үе үе өөрчилж болно.
2. “Авлигатай тэмцэх удирдамж” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 5 дугаар догол мөрд заасан “ОУСБХБ-ын зээл, ОУХА-ийн зээл, буцалтгүй тусламжаар санхүүжүүлж буй төслүүдэд залилан, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай заавар” (2006 оны



- 10-р сарын 15-ны өдөр баталж, 2011 оны 1-р сар, 2016 оны 7-р сарын 1-нд шинэчилсэн)-ыг хэлнэ.
3. “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж Монгол Улсын Засгийн газрын Зээлдэгч байгууллага, эсвэл түүний эрх, үүргийг залгамжилж авсан этгээдийг хэлнэ.
  4. “Ангилал” гэж энэ Хэлэлцээрийн 2 дугаар Хуваарийн Хэсэг III.A-ийн хүснэгтэд заасан ангиллыг хэлнэ.
  5. “Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэг” гэж Төслийн 5-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Хүлээн зөвшөөрөгдөх хямрал, онцгой байдлын үед хэрэгжүүлэх аливаа арга хэмжээ, үйл ажиллагааг хэлнэ.
  6. “CERC гарын авлага” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар хавсралтын I.E хэсэгт дурдсан гарын авлагыг хэлэх бөгөөд Төслийн үйл ажиллагааны гарын авлагын салшгүй хэсэг байна. Уг гарын авлагыг Ассоциацитай харилцан тохиролцож үе үе шинэчилж болно.
  7. “Нөөц дата төв” гэж төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, гамшгийн үед тасралтгүй ажиллагааг ханган Зээлдэгчийн компьютержуулсан өгөгдлийг байршуулах зорилгоор 2021 онд байгуулагдсан төвийг хэлнэ.
  8. “E-Mongolia портал” гэж <https://e-mongolia.mn/> веб хуудсанд (эсвэл энэ зорилгоор Зээлдэгчийн боловсруулсан ийм веб хуудас) байршуулсан цахим үйлчилгээний порталыг хэлнэ.
  9. “Хүлээн зөвшөөрөгдөх онцгой байдал, хямрал” гэдэг нь Зээлдэгчид эдийн засаг, нийгмийн томоохон сөрөг нөлөө үзүүлсэн, эсхүл үзүүлэх магадлалтай, байгалийн, эсвэл хүний үйл ажиллагаанаас үүдсэн хямрал, гамшигтай холбоотой үйл явдлыг хэлнэ.
  10. “Онцгой байдлын зардал” гэж энэхүү хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.E хэсэгт заасны дагуу “CERC гарын авлага”-д тусгасан зөвшөөрөгдөх зардлуудыг хэлэх бөгөөд Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний хэсэгт шаардагдах зардлууд байна.
  11. “Онцгой байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж Хэсэг I.E-т заасан төлөвлөгөөг хэлэх бөгөөд үүнд Хүлээн зөвшөөрөгдөх онцгой байдал, хямралын үед хэрэгжүүлэх үйл ажиллагаа,

төсөв, хэрэгжүүлэх төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.

12. “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө” буюу “БОНХТ” гэж уг Төслийн 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан байгаль орчин, нийгмийн хариуцлагын арга хэмжээний төлөвлөгөөг хэлэх бөгөөд энэ Хэлэлцээрт заасны дагуу үе үе нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Үүнд Төслөөс байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй эрсдэл, нөлөөллийг арилгахын тулд Зээлдэгчийн хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхийг шаардах материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхойлж тухайн үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, институтийн зохион байгуулалт, боловсон хүчин, сургалт, хяналт-шинжилгээ, тайлангийн зохицуулалт, тэдгээрийн дагуу бэлтгэх байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийг багтаасан байна.
13. “Байгаль орчин, нийгмийн стандарт” буюу “БОНС” гэж: (i) “Байгаль орчин, нийгмийн стандарт 1: Байгаль орчин ба нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, менежмент”; (ii) Байгаль орчин, нийгмийн стандарт 2: Хөдөлмөр ба ажиллах нөхцөл; (iii) Байгаль орчин, нийгмийн стандарт 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ ба бохирдлоос урьдчилан сэргийлэх менежмент; (iv) Байгаль орчин ба нийгмийн стандарт 4: Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал; (v) Байгаль орчин, нийгмийн стандарт 5: Газар чөлөөлөх, газар ашиглах, албадан нүүлгэхийг хязгаарлах; (vi) Байгаль орчин, нийгмийн стандарт 6: Биологийн төрөл зүйлийг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент; (vii) Байгаль орчин, нийгмийн стандарт 7: Уугуул иргэд, Сахар орчмын Африкийн хоцрогдсон уламжлалт ахуйтай нутгийн уугуул иргэдийн нийгэмлэг; (viii) Байгаль орчин, нийгмийн стандарт 8: Соёлын өв; (ix) Байгаль орчин ба нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучлагчид; (x) “Байгаль орчин, нийгмийн стандарт 10: “Сонирхогч талуудын оролцоо, мэдээллийн ил тод байдал” зэрэг Ассоциациас нийтэлж, 2018 оны 10-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон стандартуудыг бүхэлд нь хэлнэ.
14. “Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж Зээлдэгчийн Улсын бүртгэлийн ерөнхий газар, эсхүл түүний эрх, үүргийг залгамжилсан этгээдийг хэлнэ.
15. “Ерөнхий нөхцөл” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн (2020 оны 8 дугаар сарын 1, 2021 оны 4 дүгээр сарын 1, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр тус тус шинэчлэн найруулсан)

- “ОУСБХБ-ын санхүүжилт болон хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтэд зориулсан Олон улсын хөгжлийн ассоциацийн ерөнхий нөхцөл”-ийг хэлнэ.
16. “ЦХХХЯ” гэж Зээлдэгчийн Цахим хөгжил, харилцаа холбооны яам буюу түүний эрх, үүргийг залгамжилж авсан этгээдийг хэлнэ.
  17. “Үндэсний дата төв” гэж үндэсний компьютержсон өгөгдлийг байршуулах зорилгоор 2009 онд байгуулагдсан Зээлдэгчийн дата төвийг хэлнэ.
  18. “Үйл ажиллагааны зардал” гэж Төслийн үйл ажиллагааны өдөр тутмын зохицуулалт, удирдлага, хяналтын үйл ажиллагаанд шаардагдах үндэслэл бүхий зардлыг хэлэх бөгөөд үүнд тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байгууламжийн түрээсийн болон /эсвэл урсгал засвар, засвар үйлчилгээ, оффис байр, түлш, албан хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл, хэрэглээний материал, харилцаа холбооны зардал (шуудан, утас, интернэтийн зардал), унаа, орчуулга, хэвлэх, хуулбарлах зардал, банкны үйлчилгээний төлбөр, хэвлэл, сурталчилгааны зардал, даатгал, Төсөлтэй холбоотой хурлын зардал, Төсөлтэй холбоотой томилолт, амьжиргааны болон зочид буудлын зардал, хэлэлцээрт туслах ажилтан, Төсөлтэй шууд холбоотой захиргааны бусад зардал орно. Харин Зээлдэгчийн төрийн албан хаагчийн цалин, урамшуулал, шагнал, мөнгөн олговор, тэдгээртэй адилтгах төлбөр орохгүй.
  19. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 84-р догол мөрд заасан зорилгоор 2020 оны 11 дүгээр сард баталсан “Дэлхийн Банкны хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журам”-ыг хэлнэ.
  20. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж Зээлийн хэлэлцээрийн 2-р хавсралтын I.A.2 (б)-д дурдсанчлан Засгийн газрын хэрэг эрхлэх газар (эсвэл Ассоциацитай тохиролцсон өөр төрийн байгууллага)-аас үүсгэн байгуулсан, цаашид ажиллуулах алба, түүний эрх, үүргийг шилжүүлж авсан этгээдийг хэлнэ.
  21. “Төслийн үйл ажиллагааны гарын авлага” гэдэг нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар батлуулж, төсөл хэрэгжүүлэх явцад шинэчилж байх гарын авлагыг хэлэх бөгөөд дараах агуулгатай байна: (А) дараах чиглэлийн нарийвчилсан зохицуулалт, журмууд:



(а) Төслийн институтийн зохицуулалт, өдөр тутмын хэрэгжилт; (б) зарцуулалт, санхүүгийн менежмент; (в) худалдан авах ажиллагаа; (г) байгаль орчин, нийгмийн нөлөөллийг зохицуулах арга хэмжээ; (д) хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлан, мэдээлэл харилцаа; (е) ёс зүйн үйл ажиллагааны төлөвлөгөө; (ж) төрийн эрх бүхий байгууллагын өөрчлөлтөд зориулсан шилжилтийн зохицуулалт; (з) Төсөлд шаардагдах захиргаа, санхүү, техникийн болон зохион байгуулалтын зохицуулалт, дүрэм журмууд; (Б) “CERC гарын авлага”; өмнө дурдсанчлан уг гарын авлагыг Банкаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр үе үе шинэчилж болно; мөн энэхүү нэр томъёонд гарын авлагад хавсаргасан хуваариуд багтана.

22. “Төслийг удирдах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.A.2.(а)-д заасан ЗГХЭГ-аас (эсвэл Ассоциативтай тохиролцсон өөр төрийн байгууллага) байгуулж цаашид ажиллуулах хороог, эсвэл түүний эрх, үүргийг залгамжилж авсан этгээдийг хэлнэ.
23. “Гарын үсэг зурсан өдөр” гэж Зээлдэгч болон Ассоциацийн зүгээс энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр огнооны сүүлийн огноог хэлнэ. Энэ тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлд “Зээлийн хэлэлцээрийн огноо, өдөр” гэж заасан бүх агуулгад хамаарна.
24. “Сургалт” гэж Төслийн хүрээнд явагдах сургалтын үйл ажиллагаа, семинар, танилцах аялалд хамрагдсан боловсон хүчнийг оролцуулахад шаардагдах бараа, үйлчилгээний үндэслэл бүхий зардлыг хэлэх бөгөөд үүнд танилцах аялал, семинар, сургалтад оролцогчийн замын зардал, амьжиргааны зардал, сургагч багшийн үйлчилгээ авахтай холбоотой зардал, сургалт, семинарын байр талбайн түрээс, сургалтын материал бэлтгэх, олшруулах зардал, сургалт семинар, танилцах аялалд бэлтгэх, хэрэгжүүлэхтэй шууд холбоотой бусад зардал орно. Харин зөвлөхийн хөлс, Зээлдэгч талын төрийн албан хаагчдын цалин, урамшуулал, шагнал, мөнгөн олговор буюу тэдгээртэй адилтгах төлбөр орохгүй болно.

-----oOo-----

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

**Индекс:** 200003